

**УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ АУДИТ, ДОТООД ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2018 оны 12 дугаар сарын 27

Улаанбаатар хот

Гэрээнд тусгагдсан нийт ажил, үйлчилгээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа) бүрээр хүрэх түвшин	Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацааны шалгуур үзүүлэлт бүрийн хүрсэн түвшингээр)	ХУВЬ
1	2	3
НЭГ. БАЙГУУЛЛАГА (НЭГЖ)-ЫН СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ.		
5.1."Албаны хэлтэс, харьяа газруудын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж, эрсдлийн удирдлагаар хангах замаар үйл ажиллагаанд хууль тогтоомж, төрийн албаны стандартыг мөрдлөг болгох, ажлын чанар (нэгж) бүтээмжийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх" стратегийн зорилтыг хангахад чиглэсэн ажил, үйлчилгээ.		
<p>Нэгжийн ажил, үйлчилгээ. 132.1. Албаны хэлтсүүдэд батлагдсан удирдамжийн дагуу дотоодод мөрдөгдөх дүрэм журам, ХЕМ-ийн тушаал, ХЕМ-ийн зөвлөлийн хурлын шийдвэр, баримт бичгийн стандарт, албан хэрэг хөтлөлт програм хангамжийн ашиглалтын байдалд дотоод хяналт хэрэгжүүлнэ. 2-3 дугаар улиралд.</p>	<p>1.ХЕМ-ийн 2018.02.26-ны өдөр баталсан "Хот, нийтийн аж ахуйн чиглэлийн байгууллагууд болон ЗАА-нд хэрэгжүүлэх дотоод хяналт шалгалтын ажлын дэд төлөвлөгөө"-нд тусгагдсан ажлын хүрээнд "Захирагчийн ажлын албаны зарим дотоод ажилд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх ажлын удирдамж" боловсруулан батлуулж, дараах чиглэлээр хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Албаны албан хаагчид нэгжийн албан бичиг шийдвэрлэлтийн байдал, зөрчлийн тоо, • НЭЗН-ийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан ажлуудын явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ, • ХЕМ-ийн зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгавар, шийдвэрийн биелэлт /Түүвэрчилсэн хэлбэрээр/, • Баримт бичгийн стандартын хэрэгжилт /Цахим хэлбэрээр/, • Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө болон ОНХСХөрөнгөөр санхүүжигдэх бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажлын явцад мониторинг. Үнэлгээний хороодын ажлын гүйцэтгэл /Түүвэрчилсэн хэлбэрээр/. <p>Хяналт шинжилгээний ажлын гүйцэтгэл үр дүн, тайланг Хотын Ерөнхий менежерийн зөвлөлийн 2018.08.31 өдрийн 21 дүгээр хуралд танилцуулж, хэлтсүүдэд холбогдох үүрэг чиглэлийг өгч ажилласан.</p> <p>2.ХЕМ-ийн 2018 оны зөвлөлийн хурлын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээнд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны хэрэгжилт, үнэт цаасны ашиглалт, бүртгэлийн байдалд /түүвэрчилсэн хэлбэрээр/ 2018 оны 11-р сард хяналт хэрэгжүүлж, танилцуулга бэлтгэж байна.</p>	<p align="center">70%</p>